



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 1/28

Мандалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад  
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Говь-Угтаал сумын нийтийн биеийн тамирын талбайн өргөтгөлийн ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Буманбаатар (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Баатарсурэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд Ж.Уянга (Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Ч.Мандухай (Зураг төсөл зохиогч “Рэд лайн” ХХК-ийн архитектор)

Б.Мөнх-Оргил (Гүйцэтгэгч “Роуд дэвэлопмент” ХХК-ийн Менежер)

Б.Даваасурэн (Говь-Угтаал сумын Засаг даргын орлогч)

Т.Уранбайгаль (Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Б.Буманбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ

4824010129